

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ
БОДЛОГО, ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/20-15-ШТА-ГА

Даланзадгад хот 2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Аудитор Т.Хишигбат
Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn
Аудитор Г.Амарзаяа
Утас: 70533552 Цахим хаяг: Amarzayag@audit.gov.mn
Аудитор О.Чойдорж
Утас: 70533552 Цахим хаяг: Choidorjo@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/88

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9, Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй, бодлого, түүний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар болон Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт тус тус хүргүүлэхийг аудитор (Г.Амарзаяа)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор (Г.Амарзаяа)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

016010113



ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	3
ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	4
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	5
Аудитын зорилго.....	5
Аудитын хамарсан хүрээ	5
Аудитын арга зүй.....	5
Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:.....	5
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:	6
БҮЛЭГ-1 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	7
А.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. 7	
А.2. Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн, түр хамгаалах байранд ажиллах хүний нөөц дутмаг байна.	9
БҮЛЭГ-2 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСВИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	12
Б.1. Засаг захиргааны анхан шатны нэгж буюу сум, багийн түвшинд хүүхэд, гэр бүлд хүрч ажиллах, эрсдэлд хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөв, санхүү хангалтгүй байна.....	12
Б.2. Хүүхэд хамгаалаллын үйлчилгээний төсвөөс санхүүжүүлсэн урьдчилсан арга хэмжээ тэр бүр оновчтой байж чадахгүй байна.	14
БҮЛЭГ-3 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	17
В.1 Хамтарсан багийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна.....	17
В.2 Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчинд хангалтгүй байна.....	18
В.3 Насанд хүрээгүй хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд чиглэсэн нөлөөллийн ажлыг сайжруулах шаардлагатай байна.	20
ДҮГНЭЛТ.....	24
ЗӨВЛӨМЖ.....	25
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	26



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол



ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Аймгийн 2019-2023 онд хэрэгжсэн гэр бүл, хүүхэд хамгаалалтай холбоотой төсөл, хөтөлбөр.....	8
Хүснэгт 2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо	13
Хүснэгт 3. Хүүхдийн эрхийн зөрчилд холбогдсон хүүхдийн тоон мэдээлэл сумдаар.....	13
Хүснэгт 4. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвөөс Төрийн бус байгууллагад олгосон санхүүжилт	15
График 1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт болон гүйцэтгэл.....	14
График 2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг зардал тус бүрээр харуулав.....	15
График 3. НҮБ-ын хүн ам, хүүхдийн сангийн хөрөнгө оруулалт	16
График 4.Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал.....	18
График 5.Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн үзлэгээр илэрсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо.....	19
График 6. Түр хамгаалах байранд хамгаалуулсан хүүхдийн тоо	21
График 7. Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг сүм, хийд ангиллаар:	22



Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан Улсын Их Хурлын байнгын хороо, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго оршино. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх;
- Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог төрийн байгууллагуудын 2019-2023 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах, ярилцлага хийх арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэсэн.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Хүүхэд хамгааллын тухай хууль;
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр;
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл;
- НҮБ болон Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмж



Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, аудитор Т.Хишигбат, О.Чойдорж, Г.Амарзаяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.



БҮЛЭГ-1 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.1 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ийн “Хүний хөгжил” хоёрдугаар бүлгийн Зорилго 2-т *“Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ”* гэж заасан.

1.2 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-г баталсан байна. Тус чиглэлийн Зорилт 2.3-т *“Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ”*, 2.3.2-т *“Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшилийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ”* гэж тусгасан байна.

1.3 Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 2/3 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баталсан байна. Тус чиглэлд Зорилт 2.3-т *“Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ”*, 2.3.4-т *“Хүүхдийн эрхийг дээдлэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” төслийг хэрэгжүүлж, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамтад өртсөн иргэнийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлнэ”* тусгасан байна.

1.4 Аймгийг 2019-2023 онд хөгжүүлэхийн жилийн төлөвлөгөөнд хүүхэд хамгаалалтай холбоотой дараах арга хэмжээг тусгасан байна. Үүнд.

2019 он, 2020 он

- Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөр,
- Эрүүл шүд арга хэмжээ
- Хүүхэд хөгжлийн түлхүүр хөтөлбөр

2021 он

- Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөр
- Эрүүл шүд арга хэмжээ
- Сүү тараг хөтөлбөр,
- Говийн ирээдүй – Хүүхэд хөтөлбөр
- Тусгай хэрэгцээт боловсролын анги бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай багш, мэргэжилтэн бэлтгэн, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлэх,
- Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв болон гэр бүлийн боловсрол олгох, үйл ажиллагааг дэмжих, орчин нөхцөлийг сайжруулах

2022 он, 2023 он

- Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөр
- Эрүүл шүд арга хэмжээ
- “Сүү тараг” хөтөлбөр
- Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн, 6 дугаар ангид “Үдийн хоол” өгөх,
- Тусгай хэрэгцээт боловсролын анги бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай багш, мэргэжилтэн бэлтгэн, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлэх,
- Хүүхдийн эрхийг дээдлэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” төслийг хэрэгжүүлэх,
- Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ



Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

- Говийн ирээдүй – Хүүхэд хөтөлбөр
- Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв болон гэр бүлийн боловсрол олгох, үйл ажиллагааг дэмжих, орчин нөхцөлийг сайжруулах

Хүснэгт 1. Аймгийн 2019-2023 онд хэрэгжсэн гэр бүл, хүүхэд хамгаалалтай холбоотой төсөл, хөтөлбөр

№	Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр	Баталсан төсөв (сая төгрөг)				
		2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Эх хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөр	60.0	75.3	62.5	80.0	100.0
2	“Эрүүл шүд” арга хэмжээ	113.0	120.5	98.9	180.0	220.0
3	Хүүхдийн Монгол ёс заншлаа дээдэлсэн, эх оронч, авьяаслаг иргэн болгож төлөвшүүлэх “Хүүхэд хөгжлийн түлхүүр” хөтөлбөр	100.0	196.0	-	-	-
4	Бага насны хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдлаас хамгаалах, өсөлт хөгжлийг дэмжих зорилгоор “Сүү тараг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	-	-	200.0	250.0	250.0
5	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн, 6 дугаар ангид “Үдийн хоол” өгөх	-	-	-	405.5	450.0
6	Тусгай хэрэгцээт боловсролын анги бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай багш, мэргэжилтэн бэлтгэн, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлэх	-	-	10.0	150.0	150.0
7	Хүүхдийн эрхийг дээдлэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” төслийг хэрэгжүүлэх	-	-	-	115.0	225.0
8	Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ	-	-	-	125.0	125.0
9	Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв болон гэр бүлийн боловсрол олгох, үйл ажиллагааг дэмжих, орчин нөхцөлийг сайжруулах	-	-	300.0	100.0	100.0
10	Говийн ирээдүй-Хүүхэд хөтөлбөр	-	-	80.0	200.0	2,115.8
11	Хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа явуулах	-	-	-	-	20.0
Нийт дүн		273.0	391.8	751.4	1,605.5	3,755.8

Эх сурвалж: Аймгийн 2019-2023 оны баталсан төсөв

1.5 Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжих арга хэмжээнд 2022 онд 125.0 сая төгрөг батлуулан 62.5 сая төгрөг, 2023 онд 125.0 сая төгрөг батлуулан 62.5 сая төгрөгийг түр хамгаалах байрны албан хаагчдын цалин, тогтмол зардал, тохижилтод зарцуулсан байна.

1.6 "Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" 4 зорилт, 29 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг 100 хувьтай дүгнэсэн байна.

1.7 Хөтөлбөрийн хүрээнд 5 аян, 6 тэмдэглэлт өдөр, 8 арга хэмжээ, 23 удаагийн сургалт, салбар дундын байгууллагуудын 4 удаагийн уулзалт, 6 нэвтрүүлэг, 2 үзэсгэлэн, 1 уриалга, 5 төрлийн тэмцээн, 18 төрлийн гарын авлага гаргаж, 8 ТББ, 3 ААН-тэй хамтран 3,816,948 хүнд хүрсэн байна.



Хамгаалал, сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай 1171 насанд хүрэгч, 1017 хүүхдэд анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө өгч, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн, 167 иргэнийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилсан. Мөн утсанд ирсэн 201 дуудлагад кейс үйлчилгээ нээн, 90.1 хувьтай үйлчилгээ үзүүлсэн.

1.8 Салбар дундын байгууллагуудтай хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулснаар далд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлийн талаар иргэдээс ирэх дуудлага мэдээллийн тоо нэмэгдэж, гэмт хэрэг, зөрчлийн тоо 27 нэгж буюу 42.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.9 Цаашид аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, тухайн жилийн төсөвт хүүхэд хамгааллын талаарх төсөл, хөтөлбөрийг аймгийн төсөвтэй уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай байна.

A.2. Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн, түр хамгаалах байранд ажиллах хүний нөөц дутмаг байна.

2.1 Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь “Хайрын шүхэр” ТББ-тай хамтран “Өмнөговь аймгийн хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээний тайлан”-г 2020 онд гаргасан байна. Тус тайлангаар Хүүхдэд ээлтэй аймгийг хөгжүүлэхдээ 5 зорилго, 59 үйл ажиллагааг хэрэгжүүлэх санал зөвлөмжийг хүргүүлсэн байна. Таван зорилгыг дурдвал:

1. Хүүхэд бүрийн нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүртээх
2. Хүүхэд бүр эрүүл, аюулгүй орчин амьдрах нөхцөл боломжийг дээд зэргээр хангах
3. Хүүхэд бүрийг гэр бүлдээ амьдрах, тоглох, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжоор хангах
4. Аймгийн Засаг захиргаа хүүхэд бүрийг хүндэтгэж, эрх тэгш хандах
5. Хүүхдийн санал бодол, хэрэгцээ, шаардлагыг хууль тогтоомж, бодлого, журам, хөтөлбөр болон хүүхдэд нөлөөлөх шийдвэр гаргахдаа онцгойлон авч үзэх

2.2 Мөн 2023 онд “Өмнөговь аймгийн хүүхдэд ээлтэй орон нутаг үнэлгээ”-г хийсэн байна. Тус үнэлгээгээр 4 зорилтын 17 үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үүнд:

1. Хүүхдэд ээлтэй засаглал, төсөв
2. Хүүхдэд ээлтэй орчин
3. Хүүхдэд ээлтэй үйлчилгээ
4. Хүүхдэд ээлтэй хөгжилт хамгаалал

2.3 Дээрх тайлангуудын үр дүнд хүүхдийн эрх хамгааллыг сайжруулах, хөгжил оролцоог нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг хариуцлагыг нэмэгдүүлэх замаар хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 15/08 дугаар тогтоолоор 2024 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил” болгон зарласан байна.


2.4 Төрийн байгууллага, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагч, нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлага, сургалтаар хангаж ажилласан байна. Тухайлбал:

- 2020 онд Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор Даланзадгад сумын 8 багийн хамтарсан багийн 34-н хүнд арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт болон зөвлөн туслах ажил,
- 2021 онд Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах онлайн сургалт 60 хүнд,
- 2021 оны 08-р сарын 25-ны өдөр “Child helpline 108 хүүхдийн тусламжийн утасны программ” нь бүрэн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор сум багийн нийт 22 нийгмийн ажилтнуудад чадавхжуулах практик сургалт,



- 2022 онд Даланзадгад сумын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх 8-н багийн хамтарсан баг, Ерөнхий Боловсролын 6-н сургууль, сургуулийн өмнөх боловсролын 10 цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн 100-н гишүүдийг чадавхжуулах сургалт,
- 2022 онд Бага насны хүүхдийн нас, сэтгэхүйн, хөгжлийн онцлог, хүүхдийн эрх, хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргад суралцаж, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн талаар ойлголт, мэдлэгтэй, хүүхэдтэй ажиллах эв дүй, зөв хандлагатай мэргэшсэн ажилтныг чадваржуулах хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан сургалтыг 8-н хүүхэд харах төвийн 15-н хүнд зохион байгуулсан,
- 2022 онд 22 хамтарсан багийн нийгмийн бодлогын мэргэжилтэн, Даланзадгад сумын Ерөнхий боловсролын 7 сургуулийн нийгмийн ажилтан, гэр бүл, хүүхэд залуучууд хөгжлийн газрын мэргэжилтнүүд 11, сумдын Залуучуудын хөгжлийн төвийн 10-н мэргэжилтэн нийт 50-н албан хаагчдыг чадавхжуулах сургалт,
- 2022 онд Нийгмийн ажилтнуудын мэдээллийн системийн сургалтад 22 хамтарсан багийн нийгмийн бодлогын мэргэжилтэн, гэр бүл, хүүхэд залуучууд хөгжлийн газрын 6 мэргэжилтнүүд нийт 28-н албан хаагчийг хамруулсан сургалт,
- 2023 оны Гэр бүлийн боловсрол олгох үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад 2 мэргэжилтэн хамруулсан.

График 1. Сургалт зохион байгуулсан ажлын төсөв



Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын сургалтын тайлан

2.5 “Хамтдаа шалгая, хамгаалъя” аяны хүрээнд Даланзадгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн, дотуур байр, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг, эцэг эхийн зөвлөл, нийгмийн ажилтны үйл ажиллагаатай танилцаж, НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

2.6 Тус шалгалтаар Даланзадгад сумын 1-р сургуульд 5 зөвлөмж, 2-р сургуульд 8 зөвлөмж, 3-р сургуульд 7 зөвлөмж, 4-р сургуульд 6 зөвлөмж, 5-р сургуульд 7 зөвлөмж, 7-р сургуульд 3 зөвлөмж, Политехникийн 1 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

2.7 Зөвлөмжийн хэрэгжилтийг 1-р сургууль хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлсэн байна. Бусад сургууль зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

2.8 Мөн 1-р цэцэрлэг 6 зөвлөмж, 2-р цэцэрлэг 3 зөвлөмж, 4-р цэцэрлэг 7 зөвлөмж, 8-р цэцэрлэг 9 зөвлөмж, 9-р цэцэрлэг 3 зөвлөмж, 11-р цэцэрлэг 4 зөвлөмж, 23-р цэцэрлэг 6 зөвлөмж, 24-р цэцэрлэг 4 зөвлөмж, 25-р цэцэрлэг 5 зөвлөмж, 26-р цэцэрлэг 8 зөвлөмж тус тус хүргүүлсэн байна.

2.9 Тус зөвлөмжийн хэрэгжилтийг 2-р цэцэрлэг 2024 оны 01 сарын 04-ны өдрийн 01 албан бичгээр ирүүлсэн байна. Бусад цэцэрлэг хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

2.10 Цаашид хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд тавьсан хяналтын хэрэгжилтийг хангуулан ажиллах шаардлагатай байна.



2.11 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас жилийн хүүхэд хамгааллын талаарх статистик мэдээ тайланг гаргаж Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт 2019-2021 онд статистик тоон мэдээлэл хүргүүлээгүй, 2022 оны статистик тоон мэдээллийг 2022 оны 11 сарын 03-нд, 2023 оны 3-р улирлын статистик тоон мэдээллийг 2023 оны 10 сарын 17-нд албан мэйлээр хүргүүлсэн байна.

2.12 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2019-2023 оны статистик тайлан, мэдээгээр аймгийн хэмжээнд гэр бүлээсээ дайжсан, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн халамж анхаарал, хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг 0 гэж мэдээлсэн байна.

2.13 Энэ нь хүүхдүүд гэр бүлтэйгээ, эцэг, эх асран хамгаалагчийн халамж анхаарал, хяналтад байдаг гэдгийг харуулж байна.

2.14 Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга, Насан туршийн боловсролын төвийн дарга “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан насан хүрээгүй хүнд зохион байгуулагдах сургалт”-н төлөвлөгөөг батлан хууль эрх зүйн мэдлэг өгөх, амьдрах ухааны сургалт, эцэг эхийн боловсрол олгох, нийгэм сэтгэл зүй, зан үйл, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлийн дагуу сургалтыг зохион байгуулсан байна.

2.15 Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажилладаг байна.

2.16 Кэйс үйлчилгээ, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, өрхийн мэдээлэл бүртгэдэг NAMS цахим мэдээллийн системийг 2022 оноос эхлэн хэрэглэж байсан бөгөөд 2023 оны 10 сарын 23-ны өдрөөс тус системийг эзэмшигч Интерактив ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дууссан тул ашиглах боломжгүй болсон байна.

2.17 Мөн Е-тусламж түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний авсан хүүхэд, иргэдийн мэдээллийг бүртгэдэг байсан боловч одоогоор ашиглагдахгүй байна.

2.18 Шинээр Able системийг ашигладаг бөгөөд хүүхэд харах үйлчилгээ, хурдан морь уралдаанч хүүхдийн мэдээлэл, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллүүдийг бүртгэн мэдээллийн сан үүсгэж байгаа боловч систем гацах, хайлт хийхэд дутуу мэдээлэл гарч ирэх зэрэг асуудалтай байгаа учир засаж, сайжруулах шаардлагатай байна.

2.19 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт 27 хүн ажиллаж байгаагаас хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан 16 мэргэжилтэн байна. Үүнээс 5 хүн Магистр, 11 хүн нь бакалаврын зэрэгтэй байна.

2.20 Тус байгууллагад ажиллаж байгаа 27 албан хаагчдаас 7 хүн 5-аас дээш жил, 2 хүн 4-5 жил, 6 хүн 2-3 жил, 12 хүн 1 хүртэлх жил ажилласан байна.

2.21 Хүний нөөц тогтворгүй байгаа нь ажлын бус цагаар байцаалтад суух, ажил үүрэг гүйцэтгэхэд машин унааны тал дээр дутмаг, хүндрэлтэй кейстэй ажилласны дараах сэтгэл гутрал, ажлаас халшрах хам шинжтэй илрэх зэргээс шалтгаалдаг байна.

2.22 Аймгийн түр хамгаалах байр нь 1 эмч 3 ээлжийн ажилтантай үйл ажиллагаа явуулж байгаагаас эмчийн ажлаас тэтгэвэрт гарсан 1, малчнаас тэтгэвэрт гарсан 1, цэцэрлэгийн туслах багшаас тэтгэвэрт гарсан 1, багш, нийгмийн ажилтан мэргэжилтэй 1 албан хаагч байна.

2.23 Иймд хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, түр хамгаалах байрны хүний нөөцөөр хангахад анхаарч ажиллах шаардлагатай байна.



БҮЛЭГ-2 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСВИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.


Б.1. Засаг захиргааны анхан шатны нэгж буюу сум, багийн түвшинд хүүхэд, гэр бүлд хүрч ажиллах, эрсдэлд хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөв, санхүү хангалтгүй байна.

1.1 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2020, 2022 оны төсвийн төслийн саналыг хүргүүлсэн боловч ТТЗ-аас ирүүлсэн төсвийн төсөл бэлтгэх тусгай маягт, түүний зааврын дагуу боловсруулсан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

1.2 Тус газар нь 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 тоот тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны а/23 27 дугаар тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын дагуу боловсруулж хүргүүлсэн байна.

1.3 ТТЗ-д 2019, 2021 онд төсвийн төслийн санал хүргүүлсэн тухай баримт байхгүй байна.

График 2. Хүүхэд хамгаалалд үйлчилгээний төсвийн төслийн санал, батлагдсан төсөв



Эх сурвалж: Аудитын судалгаа

1.4 Дээрх нөхцөл байдал, судалгаанаас үзэхэд:

- 2019 оноос 2022 он хүртэлх хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, зардлыг судалгаанд үндэслэн төлөвлөж тооцоогүй байна.
- Хүүхэд хамгаалалд зориулсан 2023 оны төсөв, зардлыг тооцохдоо холбогдох журмыг баримтлан боловсруулсан нь өмнөх онуудтай харьцуулахад үндэслэлтэй төлөвлөлт болсон байна.

1.5 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1.6 Тус хэсэгт заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны а/23 27 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баталж мөрдүүлсэн байна.

1.7 Журмын 2-т аргачлал, зардлын норматив ашиглан хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, хэлтэст хуваарилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар тус тус даалгасан нь хүүхэд



Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг судалгаанд үндэслэн тооцож төлөвлөх үндэс болсон байна.

1.8 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нь 2019-2023 онуудад 135,183 хүүхдэд 190.1 сая төгрөг зарцуулсан ба энэ нь хүүхэд хамгаалалд зориулсан нийт төсвийн 33.9% -ийн эзэлж байна.

Хүснэгт 2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо

№	Он	Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв(сая төгрөг)	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэл(сая төгрөг)	Хүүхэд хамгааллын төсөвт урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын эзлэх хувь	Нийт урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан хүүхдийн тоо
1	2019	68.2	24.2	35.5%	22502
2	2020	79.5	28.0	35.2%	34521
3	2021	79.6	32.0	40.2%	18650
4	2022	99.4	55.2	55.5%	28232
5	2023	233.6	50.8	21.7%	29450
Нийт дүн		560.2	190.1	33.9%	133355

Эх сурвалж: Аудитын судалгаа

1.9 Орон нутгийн түвшинд хүүхэд хамгааллын үйлчилгээ болон санхүүгийн нөөц харьцангуй бэхжиж, төсөв санхүү, түр хамгаалах байртай байгаа нь үйлчилгээний хүртээмж нэмэгдэх тал дээр ахиц гарсан байна.

1.10 Харин засаг захиргааны анхан шатны нэгж буюу сум багийн түвшинд хүүхэд, гэр бүлд хүрч ажиллах, эрсдэлд хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөв, санхүү хангалтгүй байна.

Хүснэгт 3. Хүүхдийн эрхийн зөрчилд холбогдсон хүүхдийн тоон мэдээлэл сумдаар

№	Сумын нэр	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Зөрчилд холбогдсон хүүхдийн тоо(сумдаар)	Нийт зөрчилд эзлэх хувь
1	Баяндалай	-	-	-	-	-	-	-
2	Баян-Овоо	-	-	-	-	-	-	-
3	Булган	-	-	-	-	-	-	-
4	Гурвантэс	-	2	2	3	-	7	6.0
5	Мандал-Овоо	-	-	-	-	1	1	0.9
6	Манлай	-	-	-	-	-	-	-
7	Номгон	-	-	-	-	-	-	-
8	Ноён	-	-	-	-	-	-	-
9	Сэврэй	-	-	-	-	-	-	-
10	Ханбогд	4	2	4	4	3	17	14.5
11	Ханхонгор	-	-	1	-	-	1	0.9
12	Хүрмэн	-	-	1	-	-	1	0.9
13	Цогт-Овоо	-	-	-	-	-	-	-
14	Цогтцэций	-	3	6	6	11	26	22.2
15	Даланзадгад	6	6	19	16	17	64	54.7
Зөрчилд холбогдсон хүүхдийн тоо		10	13	33	29	32	117	

Эх сурвалж: Гэмт хэрэг зөрчилд холбогдсон хүүхдийн 2019-2023 оны тоон мэдээлэл

1.11 Хүүхдийн хөгжил хамгаалал, хүүхдийн эрх, хүчирхийллийн талаарх хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд



хамгааллын тогтолцоог орон нутагт бэхжүүлэхэд салбар дундын уялдааг хангах ажлыг зохион байгуулж ажилласан байна.


1.12 Цаашид засаг захиргааны анхан шатны нэгж буюу сум, багийн түвшинд хүүхэд, гэр бүлд хүрч ажиллах, эрсдэлд хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөв, санхүүг шийдвэрлэх шаардлага байна.

Б.2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвөөс санхүүжүүлсэн урьдчилсан арга хэмжээ тэр бүр оновчтой байж чадахгүй байна.

2.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны а/23 27 дугаар тушаалаар баталсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ын дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.1-д заасан нөхцөлд байгаа хүүхдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам"-д заасан шуурхай тусламжийн, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээг санхүүжүүлэхэд мөрдөнө гэж тусгажээ.

2.2 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2019-2023 онд Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөвт нийт 560.2 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, 558.5 сая төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулсан ба нийт санхүүжилтийн 99.7 хувийг зарцуулсан байна.

График 1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт болон гүйцэтгэл



Эх сурвалж: Аудитын судалгаа

2.3 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал жил бүр нэмэгдэж батлагдаж байгаа боловч 2019-2022 онд зарцуулах зориулалт, санхүүжүүлэх үүрэг, чиглэлийн талаар холбогдох хууль, журам тусгагдаагүй, төсвийн зарцуулалт, зориулалт ангилал тодорхойгүй байсан.

2.4 Мөн хүүхэд хамгааллын зардлын нэгж бүрийн жишиг норм, норматив, тариф байхгүй байгаа нь хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал нь халамжийн үйлчилгээ болон бусад салбарын зардалтай давхцах, зориулалтын бусаар ашиглах зэрэг хүндрэлүүдтэй тулгардаг байсан байна.

2.5 Харин Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны а/23 27 дугаар тушаалаар "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ыг баталж 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдүүлснээр төсвийг зориулалт бусаар зарцуулах эрсдэл буурсан байна.

2.6 Аймгийн хэмжээнд нийт хүүхдийн тоо 130139 байсан бол үүнээс эрсдэл бүлэгт байгаа хүүхдийн тоо 1822 буюу нийт хүүхдийн 0.1 хувийг эзэлж байна.


2.7 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2019-2023 онд Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн санхүүжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны а/23 27 дугаар тушаалаар баталсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг



Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн

санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ын дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд тус тус хуваарилан зарцуулсан байна.

График 2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг зардал тус бүрээр харуулав.



Эх сурвалж: Аудитын судалгаа

2.8 Сүүлийн 5 жилийн хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн зарцуулалтыг нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал тус бүрээр авч үзэхэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд зарцуулж буй зардал 2023 онд эрс нэмэгдэж байна.

2.9 Энэ нь хүүхдийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа болон үйлчилгээний эрэлт хэрэгцээ өсөж байгаатай холбоотой байна.

2.10 Мөн хүүхэд хамгаалаллын үйлчилгээний төсвөөс санхүүжүүлсэн урьдчилсан арга хэмжээ тэр бүр оновчтой байж чадахгүй байгааг харуулж байна.

2.11 Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2¹ дахь заалтын дагуу 2019-2023 онд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд 31 төрийн бус байгууллагад 30.9 сая төгрөг, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 11 төрийн бус байгууллагад 11.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 4. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвөөс Төрийн бус байгууллагад олгосон санхүүжилт

№	Он	ТББ-д олгосон санхүүжилтийн дүн			
		Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд (сая төгрөг)	ТББ-ын тоо	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд (сая төгрөг)	ТББ-ын тоо
1	2019	6.1	7	0.8	1
2	2020	3.4	6	2.7	3
3	2021	3.4	4	3.3	3
4	2022	3.1	4	2.4	3
5	2023	14.9	10	2.4	1
Дүн		30.9	31	11.5	11

Эх сурвалж: Аудитын судалгаа

2.12 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны цахим систем, mnp.gov.mn өөрийн цахим хуудас болон байгууллагын шилэн дансны мэдээллийн самбар, ил тод байдлын мэдээллийн самбарт байршуулсан байна.

¹ Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ.




2.13 Мөн хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн хөрөнгийг зарцуулсан шийдвэрийг шилэн дансны цахим системд бүрэн байршуулж хэвшсэн байна.

2.14 НҮБ-аас Монгол улсад өгсөн 5-р тайлан зөвлөмжийн дагуу уралдаанч хүүхдийн эрх хамгаалал, хөдөлмөр эрхлэгч хүүхдийн судалгаа болон хүүхдийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр жил бүр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, орон нутгийн "Говийн ирээдүй хүүхэд", "Охид, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" хөтөлбөр, Хүүхдэд ээлтэй орон нутаг санаачилга, "Хамгаалагдсан ирээдүй" хүүхдийн хөгжил хамгааллын жилийн төлөвлөгөөнд жил бүр тусгаж хэрэгжүүлж ажилласан байна.

2.15 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2019 -2023 онуудад нийт 405.8 сая төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээг НҮБ-ын хүн ам, хүүхдийн сангаас санхүүжүүлсэн байна.

График 3. НҮБ-ын хүн ам, хүүхдийн сангийн хөрөнгө оруулалт



Эх сурвалж: Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын судалгаа

2.16 Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн зарцуулалтын талаар тодорхой мэдээлэл байхгүй, санхүүжилтийн үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл тун хомс, архивын нэгж хангалттай биш байна.

2.17 Цаашид хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн зарцуулалт, үр дүнгийн талаар тодорхой мэдээллийн сан бий болгох, архивын нэгж үүсгэх шаардлагатай байна.

2.18 Тус газрын 2019-2023 оны санхүүгийн баримтад тулган баталгаажуулалт хийхэд 6.9 сая төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

2.19 Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны а/23 27 дугаар тушаалаар баталсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-тай нийцэхгүй байна.

2.20 Аудитаар аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2019-2023 он хүртэлх төсвийн төслийг шалгахад 2019, 2021 оны төсвийн төслийг шилэн дансанд мэдээлээгүй, 2020, 2022 оны төсвийн төслийг дутуу мэдээлсэн байна.

2.21 Дээрх Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1², 6 дугаар зүйлийн 6.1.3³ дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

² мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх.

³ дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлнэ.



2.22 Мөн хамгаалал, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлаас 1.6 сая төгрөгийн бэлэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 0.4 сая төгрөгийн хувцас, 1.4 сая төгрөгийн бэлэг худалдан авахад тус тус зарцуулсан байна.

2.23 Дээрх Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1⁴, 15 дугаар зүйлийн 15.1.5⁵ дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

БҮЛЭГ-3 ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

В.1 Хамтарсан багийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна.

1.1 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны А/240 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элч, Хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг тооцсон байна.

1.2 “Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элч, Хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу 15 суманд сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хяналт хийсэн байна. Хяналтаар:

- Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаа, Хүүхэд хамгааллын баг, Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, Сургуулийн дотуур байрны үйл ажиллагаа, Сургуулийн нийгмийн ажилтны үйл ажиллагаа, Багшийн ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг хамруулсан,
- Сургууль болон дотуур байрны багш нар хүүхдүүдтэй ганцаарчлан ярилцаж зөвлөгөө өгч, тэмдэглэл хөтөлдөг, эцэг эхтэй байнгын холбоотой ажилладаг, мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт нөлөөллийн ажил тогтмол зохион байгуулсан,
- Дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн амьдрах орчин болон байрны багшийн хараа хяналт сайн байна гэж үнэлэгдсэн байна.

1.3 Хяналт, шинжилгээ үнэлгээг нийгмийн орчинд, сургуулийн дотуур байрны орчинд, гэр бүлийн орчинд, хувийн зан чанарын гэсэн 4 чиглэлийг хамруулан гүйцэтгэдэг байна.

1.4 НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр 2019 онд Аймгийн 15 сумын 22 сургуульд “Миний гэр бүл, Мийний ертөнц” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

1.5 Энэхүү хөтөлбөрт нийт 6,000 хүүхэд тэдний гэр бүлийн гишүүд 20,000 гаруй хүн хамрагдаж гэр бүлийн харилцаа, санхүү, эрүүл мэнд, түүх, бахархлын талаар ойлголттой болжээ.

1.6 НҮБ-ын хүүхдийн сантай хамтран 2020 онд Даланзадгад сумын 5 дугаар сургуульд “Хүүхдийн хөгжил хамгааллын жишиг сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 46 заалт бүхий цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн байна.

1.7 Энэ хөтөлбөрийн хүрээнд “Хүүхдийн хөгжил хамгааллын жишиг сургууль” болсон ба “Аюулгүй сургууль” аргачлалыг хэрэгжүүлэх гэрчилгээг олгосон байна.

1.8 Тус аргачлалын дагуу Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран төсөл хэрэгжүүлж аймгийн 6 сургуулийн 180 гаруй багш, 3,700 сурагч, 7,030 эх эцэг хамрагдсан байна.

1.9 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага MNS6751:2019 стандарт болон холбогдох хууль тогтоомж эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэл болгож “Хөдөлмөрийн аюулгүй байдал” сарын аяны хүрээнд Даланзадгад сумын 8 багийн

⁴ Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.

⁵ төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно.



нутаг дэвсгэрт ашиглаж байгаа 42 хүүхдийн тоглоомын газруудын аюулгүй байдалд үнэлгээ хийж тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргаж ажилласан байна.

1.10 Даланзадгад сумын хэмжээнд 10 хамтарсан багаас 3 баг нийгмийн ажилтантай бөгөөд бусад нь нийгмийн ажилтан байхгүй, багийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт байхгүй байна

1.11 Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар сургууль, цэцэрлэгийн хүүхэд, хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцтай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг боловч хүүхэд хамгааллын бодлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг үнэлэхдээ нийгэмд гарч буй эерэг нөлөөг үнэлдэггүй байна.

В.2 Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчинд хангалтгүй байна.

2.1 Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллага, аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлүүдэд газрын даргын албан бичгээр чиглэл хүргүүлж ажилласан байна.

2.2 Аймгийн хэмжээнд 153 эцэг эхийн зөвлөл ажиллаж байгаагаас хүүхэд хамгааллын бодлоготой байгууллага 69, хүүхдийн өрөөтэй байгууллага 55 байна.

2.3 Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган байгууллагын нөөц боломжид тулгуурлан байгууллагууд хүүхдийн өрөөг тохижуулсан байна.


2.4 "Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого", "Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого"-ыг Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 22 сургууль, 30 цэцэрлэг батлан хэрэгжүүлж байна.

2.5 Даланзадгад сумын сургуулиудын нийгмийн ажилтнуудтай хийсэн уулзалтаар сургууль дээр зохиогдож байгаа соёл, спортын үйл ажиллагааг нийгмийн ажилчид зохион байгуулж ажилладаг нь хүүхдэд чиглэсэн нөлөөллийн ажлыг хангалттай хийх цаг хүрэлцдэггүй, бага, дунд, ахлах ангид тус бүр 1 нэг нийгмийн ажилтан байвал хүүхдүүдэд илүү хүрч нөлөөлж болохоор байна гэж саналыг дэвшүүлж байсан.

2.6 Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу Хамтарсан багийн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа чухал байдаг.

2.7 Эрүүл мэндийн байгууллага нь түр хамгаалах байр, 108 утсанд ирсэн дуудлага мэдээлэл, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг тогтмол эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулдаг байна.

График 4.Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал




Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын хэрэгжилтийн тайлан.

2.8 Эрүүл мэндийн үзлэгт 2019-2023 онд ерөнхий боловсролын сургуулийн 72,691 хүүхэд хамрагдсан байна. Үзлэгээр 72 хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байсныг илрүүлжээ.



График 5.Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн үзлэгээр илэрсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо



Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар

2.9 Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 2 охиныг бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмэгтэйчүүдийн тасагт хэвтэн эмчлүүлсэн байна. Ураг төрлийн болон таньдаг хүндээ хүчиндүүлсэн тохиолдолд хуулийн байгууллагад мэдээлдэггүй, мэдээлсэн ч томчууд хоорондоо тохиролцоод хүүхэд хохироод үлддэг асуудал байсаар байгаа нь хохирогчийн эрх ашгийг бүрэн төлөөлж чадахгүй байгааг харуулж байна.

2.10 Хамтарсан баг 2019-2023 онд нийт 47 удаа хуралдсан байна. Үүнээс эрүүл мэндийн ажилтан 28 удаа хуралд очсон нь оролцоо хангалтгүй байгааг харуулж байна.

2.11 Цаашид эрүүл мэндийн ажилтан хамтарсан багийн хуралд бүрэн оролцох шаардлагатай байна.

2.12 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Соёл урлагийн газрын даргын хамтарсан 2022 оны А/242, А/76 дугаар тушаалаар “Соёл, спорт олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах журам”-ыг баталсан байна.

2.13 Соёл, спорт олон нийтийн арга хэмжээнд хүүхдийг оролцуулах журмын 3.1.9 дахь заалтын хүрээнд Хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавин эрсдэлээс хамгаалж хувцасны стандартыг хангаж хувцасласан байдлыг үзэн, эцэг эхийн зөвшөөрлийг авч, эрсдэлийн даатгалд хамруулсан байна.

2.14 Мөн эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийн дагуу 2023 онд Хөдөлмөр зуслан арга хэмжээнд 150 хүүхдийг хамруулсан байна.

2.15 Аймгийн хэмжээнд 22 хамтарсан баг 256 гишүүдтэй үйл ажиллагаа явуулж байна. Гамшгийн үеийн эрсдэлд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн зураглал гаргаж, түргэвчилсэн үнэлгээ хийн, хоол хүнсний дутагдалтай 40 өрх 12 иргэн, 220 гаруй хүүхдэд 12 сумын нийгмийн ажилтнуудад 13 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнд 3.7 сая төгрөгийн болон хичээлийн дэмжлэг үзүүлж хомсдолтой иргэдэд хүрч очин үйлчилгээг үзүүлж, нөхцөл байдлын үнэлгээ, кейс бүрдүүлэлт хийж шаардлагатай өрх гэр бүлийг хамтарсан багт холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн байна.

2.16 Мөн “Бяцхан доктор” ажлын хүрээнд Хүүхдийн хүчирхийлэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, цахим орчны хүрээн дэх эрүүл мэнд, сөрөг нөлөө, өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл зөв хооллолтын талаар аяныг зохион байгуулснаар аяны хүрээнд байгууллагуудын эцэг эх, сурган хүмүүжүүлэгчид хүүхдийн осол гэмтлийн талаар шинэ санал санаачилга гарган ажилласан байна.

2.17 Аянд нийт 12 сумын бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, 8 сумын өрхийн эрүүл мэндийн төвүүд идэвхтэй оролцож 3760 сурагч, 400 багш, 876 эцэг эх оролцож мэдлэг мэдээллээ нэмэгдүүлсэн байна.



2.18 Даланзадгад сумын нутагт бүртгэлтэй 10 цахим тоглоомын газарт гал түймрээс урьдчилан сэргийлэн хяналт шалгалт хийж, 6-н газрын үйл ажиллагааг зогсоосон байна.

2.19 Байгууллагын веб сайт болон Фэйсбүүк хуудсыг удирдан ажиллуулж хүүхэд , гэр бүлд зориулан гамшгийн үеийн 6 төрлийн зөвлөмж нийтэлсэн.

2.20 Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна. Хэлэлцүүлэгт 120 гаруй иргэд оролцож 14 хүн санал хүсэлтээ хэлж 49 санал бичгээр ирсэн байна.

2.21 Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын санаачилгаар “Хөдөлмөр зуслан”-гийн үйл ажиллагааны үр дүнд хүүхдүүд малын гэдэс арилгаж, түлээ хагалж, цагаан идээ хийж, гэр барьж, гал түлж хоол хийж сурсан байна.

2.22 Мөн байгууллага нөөц боломждоо тулгуурлан хүүхдийн өрөөг тохижуулж байгаа нь хүүхэд хараа хяналттай байх нөхцөл боломж бүрдэж байна. Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага жил бүр өсөж байгаа нь нэг талаараа нөлөөллийн ажил сайн хийгдэж байгаа нь харагдаж байна.

В.3 Насанд хүрээгүй хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд чиглэсэн нөлөөллийн ажлыг сайжруулах шаардлагатай байна.

3.1 “Хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах цоо шинэ зохицуулалтад насанд хүрээгүй хүнтэй гуравласан хөдөлмөрийн гэрээ байгуулахтай холбоотой зохицуулалтыг нарийвчилж, 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын нөхцөл, 15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулах бүрд хүүхдийн эрхийн байцаагчаас зөвшөөрөл авах, насанд хүрээгүй хүнийг ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллуулах, уртын ээлжээр ажиллуулахыг хориглосон хүүхдэд ээлтэй эрх зүйн зохицуулалттай болсон байна.

3.2 Хүүхдийн эрхийн тухай конвенцын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн 5 жил тутамд тайланг хүргүүлж ажилладаг байна.

3.3 НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын 5 дугаар тайланд өгсөн дүгнэлт зөвлөмжийн явцын хэрэгжилтийн 2021 онд Хүүхдийн хөдөлмөрийн байдалд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх үйл ажиллагааны удирдамжийн дагуу хийсэн ажлын тайланд Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль болон холбогдох тогтоол шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтийг хангах, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хяналт шинжилгээ үнэлгээний нэгжээс 2021 оны 05 дугаар сард хүүхдийн хөдөлмөрийн байдалд хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн байна.

3.4 Даланзадгад сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 8 машин угаалгын газар, 12 дэлгүүр, худалдааны газрууд, 4 барилга, үйлдвэрлэл эрхлэгчид хяналт шинжилгээ үнэлгээнд хамрагдсан байна.

3.5 Үйлчилгээний газрууд насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахдаа хөдөлмөрийн гэрээ хийгээгүй, эцэг эхээс нь зөвшөөрөл аваагүй, автомашин угаалгын газар ажиллаж байгаа хүүхдийг зориулалтын хувцас хэрэглэгдэхүүнээр хангаагүйн улмаас нойтон хувцастай ажиллаж байсан зөрчил илэрсэн байна.

3.6 Илэрсэн зөрчилд хариу арга хэмжээ авч ажил олгогч болон насанд хүрээгүй ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.

3.7 Даланзадгад сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, насанд хүрээгүй хүүхэд ажиллуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн судалгаа гаргасан байна.



3.8 Холбогдох хууль тогтоомжийн талаар, гарын авлага, тараах материал бэлтгэн тарааж ажилласан. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хяналт шинжилгээ үнэлгээний баг ажиллаж, хүүхдийн хөдөлмөрийн байдалд хяналт үнэлгээ хийж, зөвлөн тусалсан байна. Тухайн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хууль сурталчлах нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.


3.9 Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдтэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, тэдний тулгамдсан асуудлыг тодорхойлж, ажил олгогчдод зөвлөгөө мэдээлэл өгч ажиллажээ.

3.10 Авто угаалгын газар ажиллаж байгаа хүүхдийн ажиллах орчинд хүүхэд усны гуталтай боловч дээгүүр цамц нь ус нэвтэрдэг хүйтэн өдөр даардаг, дуу чимээ ихтэй нөхцөлд ажиллах нь хүүхдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлөх эрсдэлтэй байна. Зарим ажил олгогч өмнө нь насанд хүрээгүй хүүхэд ажиллуулж байсан боловч ажиллуулахад хүндрэлтэй гэсэн шалтгаанаар хүүхэд ажиллуулдаггүй байна.

3.11 Соёл, спорт олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг нь хамгаалах журмын хүрээнд Өмнөговь аймагт зохион байгуулсан урлаг, спортын 7 төрлийн улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд эцэг, эх асран хамгаалагчийн зөвшөөрөл гэнэтийн ослын даатгалд хамруулж аюулгүй байдал хангаж байгаа эсэх дээр хяналт тавьж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

3.12 108 утсанд ирсэн дуудлага, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн мөрөөр шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажиллан, ирсэн дуудлага бүрийг харьяалах хамтарсан багт нь шилжүүлж, кейс хариу үйлчилгээнд хяналт тавьж ажилладаг байна.

График 6. Түр хамгаалах байранд хамгаалуулсан хүүхдийн тоо



Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын хэрэгжилтийн тайлан.

3.15 Түр хамгаалах байранд хамгаалуулсан 291 гэр бүлийн, 423 хүүхдэд 8636 хүн/ өдрийн үйлчилгээ үзүүлсэн байна.

3.16 Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын 2016 оны А/42 дугаар тушаалаар "Хүүхэд хамгааллын хамтарсан багийн хариу үйлчилгээний маягыг батлах тухай" Хүүхдийн эрсдэлийн үнэлгээний дагуу үнэлж, кейс төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг байна.

3.17 Монгол улсын шадар сайдын 2021 оны 57 дугаар тушаалаар халдварт /Ковид цар/ тахлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг Даланзадгад сумын 8 багийн зорилтод өрхийн 66 хүүхэд коронавирус туссан 34 хүүхэд, олон хүүхэдтэй 70 өрхөд амин дэм болон хоол тэжээлийн дэмжлэг үзүүлж. Коронавирус туссан хүүхдүүдийн ар гэртэй холбогдож давтамжтайгаар 28 удаа сэтгэл зүйн зөвлөгөөг өгсөн байна.


3.18 Өмнөговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээ түр хамгаалах байр 2019 оны 09 сард байгуулагдан тасралтгүй гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод хамгааллын үйлчилгээг 24 цагаар үзүүлж байна.



3.19 Хүүхэд хамгааллын эрсдэлийн программ дээр бүртгэгдсэн 934 хүүхдээс өндөр эрсдэлтэй 100 хүүхдийг гэнэтийн ослын эрсдэл болон, бүх төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэнэтийн ослын цогц даатгалд даатгуулсан нь үр дүнтэй ажил болсон байна.

3.20 Аймгийн Маанийн хийд болон христийн сүмийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ, Тагнуулын газар, Цагдаагийн газартай хамтран хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтаар нийт 36 сүм хийд үйл ажиллагаа явуулдаг байна.

График 7. Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулдаг сүм, хийд ангиллаар:



Эх сурвалж: Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар

3.21 Аймгийн хэмжээнд нийт 14 сумын 36 сүм хийд үйл ажиллагаа явуулж байна. Тус сүм хийдүүд "Хүүхэд хамгааллын бодлого", хүүхдээс өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх мэдээлэх дүрэм, журам байхгүй, хүүхдийг хүлээн авахдаа эмчийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэл хөтлөх, хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл ахуйн зөв дадал, зан үйлд сургах, өсөлт, хөгжил, зан төлөвт гарч буй өөрчлөлтийг ажиглан холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хийдийн лам, санваартан, багш, ажилтан, суралцагч нарт хүүхдийн эрх хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар үе шаттай сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөө байдаггүй байна.

3.22 Аймгийн Маанийн хийд дотуур байргүй учир зуны амралтаараа өдрийн цагаар маанийн хийдэд шавилан суудаг 3 хүүхэд байна. Уг 3 хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд сурдаг байна.

3.23 Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхдийн эсэн мэнд амьдрах, боловсрол эзэмших, хөгжих эрхийг хязгаарлахгүй, зөрчихгүй байх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, хүүхэд чөлөөт цагаараа тоглох, өөрийгөө хөгжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлээгүй зэрэг зөрчил дутагдал илэрснийг арилгахаар Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2023 оны дугаар А/159 тоот зөвлөмжийг хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна.

3.24 Хүүхэд нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01/1724 тоот чиглэлийн дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс "Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт шинээр шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам", зөвшөөрөлтэй шашны байгууллага сүм, хийдтэй байгуулах "Хариуцлагын гэрээ"-ний загварыг батлан хүргүүлсэн байна.

3.25 Аймгийн хэмжээнд гэмт хэрэг зөрчилд холбогдсон, болон хохирсон, гэр бүлийн үл хайхрах, бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүд жил бүр нэмэгдэх хандлагатай байна. Үүнтэй холбоотой хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд, байгууллага бүр дээр сургалт, нөлөөллийн ажлыг хийдэг байна. Мөн хэвлэл мэдээллээр шторк бэлдэн гаргасан байна.



3.26 Аймгийн хэмжээнд 0-18 насны 28310 хүүхэд байгаагаас эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 248 хүүхэд байна. 2023 онд хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос 5,0 сая төгрөгийг шийдвэрлэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн 6 охины өмгөөллийн зардалд, аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хүүхэд хамгааллын зардлаас 8 хүүхдийн өмгөөллийн зардалд 4.8 сая төгрөгийн зардлыг тус тус зарцуулсан байна.

3.27 Нийт гарч байгаа кейс хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгаан бол эцэг эхийн хараа хяналтгүй байдал, архидалт, уул уурхайтай, явуулын хүн ам ихэссэнтэй холбоотой байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн, түр хамгаалах байранд ажиллах хүний нөөц дутмаг байна.
- Засаг захиргааны анхан шатны нэгж буюу сум, багийн түвшинд хүүхэд, гэр бүлд хүрч ажиллах, эрсдэлд хүчин зүйлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төсөв, санхүү хангалтгүй байна.
- Хүүхэд хамгаалаллын үйлчилгээний төсвөөс санхүүжүүлсэн урьдчилсан арга хэмжээ тэр бүр оновчтой байж чадахгүй байна.
- Хамтарсан багийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал байхгүй байна.
- Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт гэр бүлийн орчинд хангалтгүй байна.
- Насанд хүрээгүй хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдэд чиглэсэн нөлөөллийн ажлыг сайжруулах шаардлагатай байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Б.Эрдэнэцэцэг танаа:

- Шилэн дансны цахим системд мэдээ, мэдээлэл байршуулахдаа мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, заасан хугацаанд байршуулж хэвших.
- Нууцын зэрэглэлтэй хавтаст баримтад хамтарсан багийн шийдвэр, хурлын тэмдэглэлийг бүрэн оруулж байх
- Хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗАР

Багш хөгжлийн ордон, 3 давхар, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 70532105
Цахим шуудан: umnugobi@cfa.gov.mn

2024.10.25 № 324
танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаарх гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтэд өгөх санал тайлбар байхгүй болно.

Аудитаар илэрсэн зөрчлийг хариуцсан мэргэжилтэн, холбогдох албан байгууллагуудаар дамжуулан алдааг дахин гаргахгүй байхыг анхаарч ажиллах болно.

ДАРГА

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ



164240378

D:\2024\alban bichig\Jijig-toot-2024.Do